



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот 15170, Утас: 26 15 44,
Цахим шуудан: info@supremecourt.mn

2024.05.24 № 05/3268

танай _____-ны № _____-т

**Тендер шалгаруулалтыг
үргэлжлүүлэх тухай**

Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240101002 дугаартай “Их засварын ажил” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг сонирхогч этгээдээс гомдол гаргасантай холбогдуулан түр түдгэлзүүлсэн.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01/933 дугаар “Тендерийн баримт бичиг хянасан тухай” албан бичгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж 15 дугаар зүйлийн 15.5-д “Гэрээний үүргийг гүйцэтгэхэд хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөл эсхүл гэрчилгээ шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж тус тус заасны дагуу захиалагч тендерийн баримт бичгийг боловсруулсан тухай тусгаж, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг мэдэгдсэн байна.

Иймд Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газраас зарласан УДШ/20240101002 дугаартай “Их засварын ажил” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг баримт бичгийн тендер хүлээн авах эцсийн хугацаа болон тендер нээх хугацааг өөрчлөн үргэлжлүүлж байгааг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА



С.ЗАЯАДЭЛГЭР